MONGOLIAN
STOCK EXCHANGE

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 27 өдөр Дугаар 34 Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерыг гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.

2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Голомт Капитал ҮЦК” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Голомт Капитал ҮЦК” ХХК /С.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын бэк оффис (back office)-ын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө дуусгахыг “Голомт Капитал ҮЦК” ХХК /С.Ган-Эрдэнэ/-д даалгасугай.

5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ТОГТОХБАЯР

Монголын Хөрөнгийн Бирж
УХА 0163

15?3010093

ТӨСӨЛ

Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах
брокерыг гишүүнээр элсүүлэх тухай

2023 оны 10 сарын 27-ны өдөр №... Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.

2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу "Голомт Капитал ҮЦК" ХХК-тай "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ" байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг "Голомт Капитал ҮЦК" ХХК /С.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын бэк оффис (back office)-ын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө дуусгахыг "Голомт Капитал ҮЦК" ХХК /С.Ган-Эрдэнэ/-д даалгасугай.

5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ТОГТОХБАЯР

**ҮНДЭСЛЭЛ**

Компанийн тухай хууль

76.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

76.1.18.Энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

48.1.Хөрөнгийн биржийн арилжаанд энэ хуульд заасан бүртгэлд хамрагдсан брокер, дилер, андеррайтер оролцоно

Компанийн дүрэм

5.7.20 Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнээс хасах

Гишүүнчлэлийн журам

3.2.1 Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж нь элсэх хүсэлт гаргагчийн баримт бичгийн бүрдэл, биржийн гишүүн оролцогчид тавих шаардлага хангасан эсэхийг хянаж, гишүүнээр элсүүлэх эсэх талаар саналаа ТУЗ-д гаргаж, ТУЗ-өөр шийдвэрлүүлнэ.